**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:**
**БНА-2023/165/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2023 оны 02 дугаар сарын 25


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга........................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа........................................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........................................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ........................................
4. Аудитын тайлан........................................
   4.1 Ерөнхий зүйл ........................................
   4.2 Материаллаг байдал ........................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................
5. Аудитын илрүүлэлт ........................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ........................................


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХҮГ | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/45

танай ______________ -ны № ________________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Э.ЭНХТӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Амьжиргаа дэмжих зөвлөлийн 35.7 сая, НҮБ-ийн хүүхдийн сангийн 17.9 сая, ХШҮГ-ын дотоод албан томилолт 2.0 сая, мэдээлэл хүргэх маягт хэвлэх 4.0 сая, тендерийн хураамжийн 0.6 сая төгрөг тус тус төвлөрч бүрэн зарцуулсан байна.

005020235

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022.04.29-ний өдөр батлагдаж тус газрын дэд даргын орон тоо байхгүй болсон бөгөөд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд 2022 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 01/1522 тоот албан бичгээр дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх чиглэл ирүүлж, Хөдөлмөрийн тухай хуулийн 79.2-т заасны дагуу мэдэгдсэнд тооцож, мэдэгдэл хүргүүлснээс 30 хоногийн дотор буюу 2022 оны 06 дугаар сарын 28-ний өдөр үүрэгт ажлаас нь чөлөөлсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 120 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D/2023-A4 Alban toot.doc

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,037,024.00** | **10,572,024.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 10,037,024.00 | 10,572,024.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 10,037,024.00 | 10,572,024.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 865,000.00 | 1,400,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,172,024.00 | 9,172,024.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **226,950,258.15** | **205,983,337.92** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 226,950,258.15 | 205,983,337.92 |
| **392** | **Биет хөрөнгө** | 209,450,258.15 | 188,483,337.92 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 145,772,177.00 | 145,772,177.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -15,467,611.68 | -20,623,482.24 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 57,568,276.00 | 61,799,476.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -13,308,822.21 | -24,826,883.26 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 74,466,333.00 | 74,466,333.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -39,580,093.96 | -48,104,282.58 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 17,500,000.00 | 17,500,000.00 |
| 39301 | Програм хангамж | 7,655,000.00 | 7,655,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -7,655,000.00 | -7,655,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 17,500,000.00 | 17,500,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **236,987,282.15** | **216,555,361.92** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **236,987,282.15** | **216,555,361.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 236,987,282.15 | 216,555,361.92 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,454,481,459.57 | 1,454,481,459.57 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,454,481,459.57 | 1,454,481,459.57 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -1,261,474,741.99 | -1,281,906,662.22 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -1,261,474,741.99 | -1,261,474,741.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -20,431,920.23 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 43,980,564.57 | 43,980,564.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **236,987,282.15** | **216,555,361.92** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан / төгрөгөөр /

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **840,272,647.00** | **873,281,533.00** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,693,947.00** | **4,231,200.00** |
| **Нийтлэг татварын бус орлого** | 27,693,947.00 | 4,231,200.00 |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **812,578,700.00** | **869,050,333.00** |
| **Улсын төвлөрсөн төсвөөс** | 796,343,700.00 | 801,240,529.00 |

| | | |
|---|---|---|
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 796,343,700.00 | 801,240,529.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,235,000.00 | 67,809,804.00 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 18,479,804.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,500,000.00 | 48,700,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 735,000.00 | 630,000.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **844,904,665.47** | **893,713,453.23** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **844,904,665.47** | **893,713,453.23** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 787,447,478.57 | 833,239,513.64 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 591,438,165.00 | 602,671,533.00 |
| Үндсэн цалин | 418,333,624.00 | 445,441,422.00 |
| Нэмэгдэл | 160,002,041.00 | 115,785,952.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 13,102,500.00 | 18,411,500.00 |
| Урамшуулал | 00.00 | 23,032,659.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,254,095.73 | 76,005,384.48 |
| Тэтгэврийн даатгал | 54,014,113.42 | 52,060,333.33 |
| Тэтгэмжийн даатгал | 5,430,124.28 | 5,815,489.45 |
| ҮОМШӨ-ний даатгал | 4,806,129.30 | 5,172,517.60 |
| Ажилгүйдлийн даатгал | 1,111,368.67 | 1,173,686.67 |
| Эрүүл мэндийн даатгал | 11,892,360.06 | 11,783,357.43 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57,140,794.91 | 55,272,728.00 |
| Гэрэл, цахилгаан | 4,189,314.91 | 4,546,922.00 |
| Түлш, халаалт | 51,167,424.00 | 47,969,460.00 |
| Цэвэр, бохир ус | 1,784,056.00 | 2,756,346.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 9,463,097.46 | 4,549,783.93 |
| Бичиг хэрэг | 3,409,450.00 | 1,376,550.00 |
| Тээвэр, шатахуун | 1,951,500.00 | 330,935.25 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,883,547.46 | 1,810,248.68 |
| Ном, хэвлэл | 45,000.00 | 00.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 90,000.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,173,600.00 | 942,050.00 |
| **Нормативт зардал** | 368,000.00 | 120,000.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 368,000.00 | 120,000.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,450,000.00 | 27,000.00 |
| Урсгал засвар | 1,450,000.00 | 27,000.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,831,660.00 | 69,394,964.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,514,000.00 | 67,274,804.00 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,130,000.00 | 1,092,500.00 |
| Даатгалын үйлчилгээ | 200,000.00 | 200,000.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 77,500.00 | 81,000.00 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 559,500.00 | 396,000.00 |
| Газрын төлбөр | 317,660.00 | 317,660.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,501,665.47 | 25,198,120.23 |

| | | |
|---|---|---|
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 30,501,665.47 | 25,198,120.23 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 57,457,186.90 | 60,473,939.59 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 54,093,981.78 | 46,625,902.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 53,224,981.78 | 41,319,073.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 869,000.00 | 5,306,829.00 |
| **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,363,205.12 | 13,848,037.59 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,361,705.12 | 13,848,037.59 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-4,632,018.47** | **-20,431,920.23** |
| **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-4,632,018.47** | **-20,431,920.23** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **812,578,700.00** | **869,050,333.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **812,578,700.00** | **869,050,333.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 796,343,700.00 | 801,240,529.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 796,343,700.00 | 801,240,529.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,235,000.00 | 67,809,804.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 18,479,804.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,500,000.00 | 48,700,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 735,000.00 | 630,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **812,578,700.00** | **869,050,333.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **812,578,700.00** | **869,050,333.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **755,121,513.10** | **808,576,393.41** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 591,438,165.00 | 602,671,533.00 |
| 210101 | Үндсэн цалин | 418,333,624.00 | 445,441,422.00 |
| 210102 | Нэмэгдэл | 160,002,041.00 | 115,785,952.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,102,500.00 | 18,411,500.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 23,032,659.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,254,095.73 | 76,005,384.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,014,113.42 | 52,060,333.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,430,124.28 | 5,815,489.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,806,129.30 | 5,172,517.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,111,368.67 | 1,173,686.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,892,360.06 | 11,783,357.43 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57,140,794.91 | 55,272,728.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,189,314.91 | 4,546,922.00 |
| 210302 | Түлш, халаалт | 51,167,424.00 | 47,969,460.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,784,056.00 | 2,756,346.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,713,097.46 | 4,549,783.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,659,450.00 | 1,376,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,951,500.00 | 330,935.25 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,883,547.46 | 1,810,248.68 |
| 210404 | Ном, хэвлэл | 45,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 90,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,173,600.00 | 942,050.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 155,000.00 | 120,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 155,000.00 | 120,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,869,200.00 | 27,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 419,200.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,450,000.00 | 27,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,551,160.00 | 69,929,964.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,233,500.00 | 67,809,804.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,130,000.00 | 1,092,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,000.00 | 200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 77,500.00 | 81,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 559,500.00 | 396,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 317,660.00 | 317,660.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **57,457,186.90** | **60,473,939.59** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 54,093,981.78 | 46,625,902.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 53,224,981.78 | 41,319,073.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 869,000.00 | 5,306,829.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,363,205.12 | 13,848,037.59 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,361,705.12 | 13,848,037.59 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 00.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | 00.00 | 00.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 00.00 | 00.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,454,481,459.57 | 43,980,564.57 | -1,256,842,723.52 | 00.00 | 241,619,300.62 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,454,481,459.57** | **43,980,564.57** | **-1,256,842,723.52** | **00.00** | 241,619,300.62 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -4,632,018.47 | 00.00 | -4,632,018.47 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,454,481,459.57** | **43,980,564.57** | **-1,261,474,741.99** | **00.00** | 236,987,282.15 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,454,481,459.57** | **43,980,564.57** | **-1,261,474,741.99** | **00.00** | 236,987,282.15 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,454,481,459.57** | **43,980,564.57** | **-1,261,474,741.99** | **00.00** | 236,987,282.15 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -20,431,920.23 | 00.00 | -20,431,920.23 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,454,481,459.57** | **43,980,564.57** | **-1,281,906,662.22** | **00.00** | 216,555,361.92 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 802,102,200.00 | 787,392,491.41 | 14,709,708.59 | 98.2 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 802,102,200.00 | 787,392,491.41 | 14,709,708.59 | 98.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 753,599,000.00 | 740,766,589.41 | 12,832,410.59 | 98.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 612,968,700.00 | 602,671,533.00 | 10,297,167.00 | 98.3 |
| 210101 | Үндсэн цалин | 463,950,000.00 | 445,441,422.00 | 18,508,578.00 | 96.0 |
| 210102 | Нэмэгдэл | 124,882,500.00 | 115,785,952.00 | 9,096,548.00 | 92.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,136,200.00 | 18,411,500.00 | 5,724,700.00 | 76.3 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 23,032,659.00 | -23,032,659.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,291,100.00 | 76,005,384.48 | 1,285,715.52 | 98.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,648,300.00 | 52,060,333.33 | 587,966.67 | 98.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,160,700.00 | 5,815,489.45 | 345,210.55 | 94.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,928,500.00 | 5,172,517.60 | -244,017.60 | 105.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,232,200.00 | 1,173,686.67 | 58,513.33 | 95.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,321,400.00 | 11,783,357.43 | 538,042.57 | 95.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,417,300.00 | 55,272,728.00 | 144,572.00 | 99.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,678,900.00 | 4,546,922.00 | -868,022.00 | 123.6 |
| 210302 | Түлш, халаалт | 45,256,800.00 | 47,969,460.00 | -2,712,660.00 | 106.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,481,600.00 | 2,756,346.00 | 3,725,254.00 | 42.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,856,800.00 | 4,549,783.93 | 307,016.07 | 93.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 868,200.00 | 1,376,550.00 | -508,350.00 | 158.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,391,600.00 | 330,935.25 | 1,060,664.75 | 23.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,539,400.00 | 1,810,248.68 | -270,848.68 | 117.6 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 114,600.00 | 90,000.00 | 24,600.00 | 78.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 943,000.00 | 942,050.00 | 950.00 | 99.9 |
| **2105** | **Нормативт зардал** | 121,700.00 | 120,000.00 | 1,700.00 | 98.6 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 121,700.00 | 120,000.00 | 1,700.00 | 98.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 366,800.00 | 27,000.00 | 339,800.00 | 7.4 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 327,700.00 | 00.00 | 327,700.00 | 0.0 |
| 210604 | Урсгал засвар | 39,100.00 | 27,000.00 | 12,100.00 | 69.1 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,576,600.00 | 2,120,160.00 | 456,440.00 | 82.3 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 416,000.00 | 200,000.00 | 216,000.00 | 48.1 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 158,500.00 | 81,000.00 | 77,500.00 | 51.1 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 117,300.00 | 33,000.00 | 84,300.00 | 28.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 474,300.00 | 396,000.00 | 78,300.00 | 83.5 |
| 210807 | Газрын төлбөр | 318,000.00 | 317,660.00 | 340.00 | 99.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 48503200.00 | 46625902.00 | 1,877,298.00 | 96.1 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 48,503,200.00 | 46,625,902.00 | 1,877,298.00 | 96.1 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 42,334,700.00 | 41,319,073.00 | 1,015,627.00 | 97.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,168,500.00 | 5,306,829.00 | 861,671.00 | 86.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 802,102,200.00 | 801,240,529.00 | 861,671.00 | 99.9 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 802,102,200.00 | 801,240,529.00 | 861,671.00 | 99.9 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 802,102,200.00 | 801,240,529.00 | 861,671.00 | 99.9 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь "Халамжаас - хөдөлмөрт " эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь захиргаа хяналтын хэлтэс 16 ажилтан, хөдөлмөрийн хэлтэс 7 ажилтан, халамжийн хэлтэс 30 ажилтан 53 орон тоо батлагдаж 53 орон тоотой ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Захиргаа хяналтын хэлтэс нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХХҮЕГ-ын даргын 2018.08.06-ний өдрийн А/174 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Хөдөлмөр,халамжийн үйлчилгээний газрын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 216,555.3 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 20,431.9 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 10,037.0 | 10,572.0 | (535.0) |
| Үндсэн хөрөнгө | 302,961.8 | 307,193.0 | 4,321.2 |
| Хуримтлагдсан элэгдэл | (76,011.5) | (101,209.5) | (25,198.1) |
| **Нийт хөрөнгө** | **236,987.2** | **216,555.3** | (20,431.9) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 236,987.2 | 216,555.3 | (20,431.9) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **236,987.2** | **216,555.3** | (20,431.9) |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Авлага, өглөг данснууд нь оны эхний болон эцсийн үлдэгдэлгүй болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,572.0 мянган төгрөг болж өмнөх оноос 535.0 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын үлдэгдэлтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 205.983.3 мянган төгрөг 20,431.9 мянган төгрөгөөр буурсан нь 4,231.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж / киоск төхөөрөмж – 2,480.0 мянган төгрөг, гар скайнер – 1,751.2 мянган төгрөг/ нэмэгдэж, элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна. Тайлант онд өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 216,555.3 мянган төгрөг болж 20,431.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 20,431.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 906,176.4 мянган төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 114,506.7 мянган төгрөгөөр бууруулж 791,669.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 802,102.2 мянган төгрөг болгож 10,432.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71902, 72102 хөтөлбөрийн 80101 арга хэмжээг санхүүжүүлэхээр 802,102.2 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 787,392.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй 13,848.0 мянган төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 787,392.4 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 13,848.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71902 Нийгмийн халамж | 655,735.6 | 645,365.9 | 10,369.7 | 98.4 |
| 2 | 80101 үндсэн үйл ажиллагааны зардал | 655,735.6 | 645,365.9 | 10,369.7 | 98.4 |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 48,503.2 | 46,625.9 | 1,877.3 | 96.1 |
| 4 | 72102 Хөдөлмөр эрхлэлт | 97,863.4 | 95,400.6 | 2,462.8 | 97.4 |
| 5 | 80101 үндсэн үйл ажиллагааны зардал | 97,863.4 | 95,400.6 | 2,462.8 | 97.4 |
| | Нийт дүн | 2,144,356.8 | 2,142,386.4 | 14,709.8 | 97.5 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030017406 тоот дансанд 67,809.8 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зарцуулсан байна.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* /төгрөгөөр/

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | НҮБ-ийн хүүхдийн сангийн төслийн санхүүжилт | 17,854,804 |
| 2 | Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааны зардал | 35,700,000 |
| 3 | Тендерийн хорооны гишүүдийн зардал | 630,000 |
| 4 | Хяналт шинжилгээ үнэлгээний зардал | 2,000,000 |
| 5 | Мэдээллийн маягтын зардал | 4,000,000 |
| 6 | Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн дахин судалгааны санхүүжилт | 7,000,000 |
| 7 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн шагналын санхүүжилт | 625,000 |
| | НИЙТ ДҮН | 67,809.8 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

| № | Хөтөл бөр | Эдийн засгийн ангилал | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71902, 72102-80101 | 210101-210103 | 2022.01.01-2022.12.31 | Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу Төрийн захиргааны 45 алба хаагч, төрийн үйлилгээний 8 алба хаагч, нийт 53 алба хаагчийн 1-12 дугаар сарын цалинг бодож олгосон. | 98.3% | 612,968,700.00 | 602,671,533.00 |
| | | 210201-210205 | 2022.01.01-2022.12.31 | Алба хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээ тайланг сар | 98.3% | 77,291,100.00 | 76,005,384.00 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүр төлж, өр авлагагүй ажилласан. | | | |
| | | 210301 | 2022.01.01-2022.12.31 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын цахилгааны зардлыг тоолуурын заалтын дагуу төлж барагдуулсан. | 123% | 3,678,900.00 | 4,546,922.00 |
| | | 210302 | 2022.01.01-2022.12.31 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын гэрээний дагуу түлш халаалтын зардлыг шилжүүлсэн. | 106% | 45,256,800.00 | 47,969,460.00 |
| | | 210303 | 2022.01.01-2022.12.31 | Чандмань-Баянхонгор ХК-ай байгуулсан гэрээний дагуу төлбөрийг 100 хувь шилжүүлсэн. | 42.5% | 6,481,600.00 | 2,756,346.00 |
| | | 210401 | 2022.01.01-2022.12.31 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын алба хаагчдыг бичиг хэргийн материалаар хангаж, зардлыг 100 хувь шилжүүлсэн. | 158% | 868,200.00 | 1,376,550.00 |
| | | 210402 | 2022.01.01-2022.12.31 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын шатахууны зардал | 23% | 1,391,600.00 | 330,935.25 |
| | | 210403 | 2022.01.01-2022.12.31 | Хөдөлмөрийн халамжийн үйлчилгээний газрын шуудан хүргэлт болон цахилгаан холбооны зардалыг бүрэн төлж барагдуулсан. | 117% | 1,539,400.00 | 1,810,248.68 |
| | | 210405 | 2022.01.01-2022.12.31 | Цэвэр хот ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу хог хаягдлын зардлыг 100 хувь төлж барагдуулсан. | 78% | 114,600.00 | 90,000.00 |
| | | 210406 | 2022.01.01-2022.12.31 | Байгууллагын цэвэрлэгээний материалыг 100% бүрэн барагдуулж, алба хаагчдын цэвэр тохитой орчинд ажиллах, ажилчдын албан үүргээ гүйцэтгэх нөхцөл боломцоо хангагдсан. | 99% | 943,000.00 | 942,050.00 |
| | | 210503 | 2022.01.01-2022.12.31 | Цэвэрлэгээний алчуурын зардлыг 100 хувь төлж барагдуулан алба хаагчдыг ажиллах нөхцлөөр хангасан | 98% | 121,700.00 | 120,000.00 |
| | | 210601 | 2022.01.01-2022.12.31 | Багаж техник хэрэгслийн зардал хэмнэгдсэн. | 0% | 327,700.00 | 0.00 |
| | | 210604 | 2022.01.01-2022.12.31 | Хөлөмөр халамжийн үйлчилгээний газрын урсгал засварын зардлыг санхүүжүүлсэн. | 69% | 39,100.00 | 27,000.00 |
| | | 210802 | 2022.01.01-2022.12.31 | Аудитын төлбөрийг 100% төлж барагдуулсан. | 100% | 1,092,500.00 | 1,092,500.00 |
| | | 210803 | 2022.01.01-2022.12.31 | Тээврийн хэрэгслийн даатгалыг 100% төлж барагдуулсан | 48% | 416,000.00 | 200,000.00 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 210804 | 2022.01.01-2022.12.31 | Тээврийн хэрэгслийн татварыг 100% төлж барагдуулсан. | 51% | 158,500.00 | 81,000.00 |
| | | 210805 | 2022.01.01-2022.12.31 | Тээврийн хэрэгслийн оношилгооны төлбөр 100% төлж барагдуулсан. | 28% | 117,300.00 | 33,000.00 |
| | | 210806 | 2022.01.01-2022.12.31 | Программын төлбөрийг 100% шилжүүлж барагдуулсан. | 83% | 474,300.00 | 396,000.00 |
| | | 210807 | 2022.01.01-2022.12.31 | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын эзэмшилд байдаг газрын төлбөрийг 100% төлж барагдуулсан. | 99% | 318,000.00 | 317,660.00 |
| | | 213207 | 2022.01.01-2022.12.31 | Мэргэжилтэн Б.Нарантуяа, М.Ганболд нарт тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмжийг 100% олгосон. | 97% | 42,334.7 | 41,319.07 |
| | | 213209 | 2022.01.01-2022.12.31 | Талийгаач Д.Амарсанаа дарга, Мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нарт нэг удаагийн тэтгэмж олгосон. | 86% | 6,168.5 | 5,306.8 |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Д.Амарсанаа агсан /2022.01.01-2022.06.28 хүртэл/ газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхтөр /2022.06.28-2022.12.31 хүртэл/ 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Сайханцэцэг нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 893,713.5 мянган төгрөгөөс 8,937.1 мянган, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 6,256.0

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд нийт 802,102.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 0 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 149 | 0 | 2 |

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 856,664.7 мянган төгрөгийн 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 90,736.1 мянган төгрөгийн 12 гүйлгээ, худалдан авалттай холбоотой 47,969.5 мянган төгрөгийн 1 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,303.2 мянган төгрөгийн гэрээг Шилэн дансны сайтад мэдээлээгүй зөрчил[1] илэрснийг зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

### 5.1 Зөвлөмж

1.Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй бөгөөд гэрэл цахилгаанд 4,546.9 мянга, цэвэр бохир усны төлбөрт 2,756.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг цаг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **1** | | **0** | **0** | **0** | **0** | **1** | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | **1** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **1** | **0** |

oOo

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.